



4223

**МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,
Утас: 264216, Факс: 264460,
E-mail: info@csc.gov.mn

2019.11.19 № 01/1432
танай _____-ны № _____-т

**Хүний нөөцийн нэгдсэн
системийн тухай**

БЯАНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.ДАШЦЭРЭН ТАНАА

Бүтэц, Ажилгуулагч
Төсвийн мөнгө
захирал нэрт
мэдээлэл ажлын
харилцаа мэдээлэл
архивлаж байна
дөхөөс бүтэц
21/12

Төрийн албаны зөвлөл нь Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор "Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам", Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор "Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам, загвар"-ыг тус тус баталсан.

Дээрх хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн системийг Сангийн яамны Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системтэй холбож, мэдээлэл солилцохоор ажиллаж байна. Нэгдсэн систем ашиглалтад орсноор Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системд бүртгэгдсэн албан хаагчдын мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчийн цалин бодогдохоос гадна төрийн жинхэнэ албан тушаалд шатлан дэвшүүлэх буюу мерит зарчмыг хэрэгжүүлэх бодитой нөхцөл бүрдэх давхар ач холбогдолтой юм.

Төрийн албаны зөвлөлөөс "Мэдээлэл шинэчлэх тухай" 2019 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 255 дугаар албан бичгийг төрийн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн боловч албан хаагчдынхаа мэдээллийг шинэчлэн оруулах ажилд зарим байгууллага хайхрамжгүй хандаж, бүрэн биелүүлэхгүй байна.

Үүнээс шалтгаалж төрийн албан хаагчдын цалин буруу бодогдох эрсдэлтэй байгаа бөгөөд гарсан үр дагавар, хуулийн хариуцлагыг хүний нөөцийн системд мэдээллээ шинэчлэн оруулаагүй, үнэн зөв мэдээлээгүй төсвийн шууд захирагч бүрэн хариуцахыг анхааруулаад, төрийн албан хаагчдын цалин хөлс, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаатай холбоотой асуудалд хариуцлагатай хандаж дараах мэдээллийг Хүний нөөцийн нэгдсэн системд 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр гэхэд бүрэн шинэчилж оруулахыг үүгээр үүрэг болгож байна. Үүнд:

Нэг. Байгууллагын албан хаагчдын чөлөөлөгдсөн, халагдсан, томилогдсон, албан тушаалд шилжсэн, сэлгэсэн, дэвшсэн, албан тушаал бууруулсан гэх мэт хөдөлгөөн бүрийг бүрэн бүртгэх;

Хоёр. Албан хаагчдын үндсэн цалин, сар бүр тогтмол авдаг нэмэгдэл бүрийг байгууллагын санхүү хариуцсан ажилтнаар хянуулж мэдээллийг үнэн зөв оруулах, мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд шинэчлэн оруулах;

Гурав. Албан хаагчдын ажилласан жил, албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэвийг өөрчлөлт орсон хамгийн сүүлийн байдлаар бүртгэж, мэргэжил, мэргэшил, боловсролын талаарх мэдээллийг бүрэн оруулах; /Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан төрийн захиргааны Тэргүүн, Эрхэлсэн, Ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох албан хаагчийг сургаж бэлтгэх мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах болзол, шаардлагыг хангасан албан хаагчдын судалгааны үндсэн мэдээлэл болох юм./

Дөрөв. Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.1.4-т заасан удирдах албан тушаалтны нөөц, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын хоёрт заасан нөөцийн сангийн бүрэлдэхүүн тус бүрээр нөөцийн сангийн бүртгэлийг байгууллага бүр батлагдсан маягт /Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолын хавсралт 2,4,5/-ын дагуу гаргаж ирүүлэх;

Тав. Эдгээр мэдээллийн баяжилтыг цаашид өөрчлөлт гарсан тухай бүр хийж хэвших.

Дээрх үүргийг харьяа газрууд болон бүх салбар нэгждээ хүргүүлж, хэрэгжилтийг хангах ажлыг шуурхай зохион байгуулж Төрийн албаны зөвлөлд энэ тухай мэдээ тайлангаа 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ